



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 нэрийн, нийт 143,641,596.20 (нэг зуун дөчин гурван сая зургаан зуун дөчин нэгэн мянга таван зуун ерэн зургаан төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 28,869,114.00 (хорин найман сая найман зуун жаран есөн мянга нэг зуун арван дөрвөн) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005264  
15-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт

"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй ашиглалтын хугацаа,  
 үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа	
							Ашиглах хугацаа /жилээр/	Нийт дүн (төгрөг)
1	Насос СЭН-3 цн-400/105	3/28/2003	ш	1	3,364,680.00	3,364,680.00	2	672,936.00
2	Удирдлагын шкаф К-2	12/19/2002	ш	1	2,800,000.00	2,800,000.00	2	560,000.00
3	Удирдлагын шкаф К-3	12/19/2002	ш	1	2,800,000.00	2,800,000.00	2	560,000.00
4	Үнс баригч ХД-4*6 К-2	12/19/2002	ш	1	3,000,000.00	3,000,000.00	2	600,000.00
5	Үнс баригч ХД-4*6 К-3	12/19/2002	ш	1	3,000,000.00	3,000,000.00	2	600,000.00
6	Ялтсан дулаан солилцуур	11/2/2012	ш	1	126,671,591.00	126,671,591.00	2	25,334,318.00
7	Насос ЭЦВ-8-125/40	2/16/2012	ш	1	1,425,000.00	1,425,000.00	2	285,000.00
8	Факс	12/31/2013	ш	1	142,150.00	142,150.00	4	56,860.00
9	Компьютер персонал	9/30/2014	ш	2	219,087.60	438,175.20	2	200,000.00
						143,422,508.60	20	28,869,114.00
Нийт дүн						(нэг зуун дөчин гурван сая зургаан зуун хорин хоёр мянга таван зуун найман төгрөг жаран мөнгө)	(хорь)	(хорин найман сая найман зуун жаран есөн мянга нэг зуун арван дөрвөн төгрөг)